



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/608

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:


1. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ази номхон далайн бүсийн агаарын навигацийн төлөвлөлт, хэрэгжилтийг хангах ажлын хэсгээс дэвшүүлэн тавьсан "Систем даяарх мэдээллийн менежмент" /SWIM/-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг төсвийн дагуу гарган зарцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ч.Нямсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газар /Ё.Эрдэнэбат /-т үүрэг болгосугай.

ДАРГА /  Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн  
А/608...дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“СИСТЕМ ДАЯАРХ МЭДЭЭЛЛИЙН МЕНЕЖМЕНТ” /SWIM/-ИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Д.Үлэмж

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний  
албаны дэд дарга

Нарийн бичгийн дарга:

Х.Одхүү

Агаарын навигацийн бодлого,  
зохицуулалтын газрын нисэхийн  
мэдээллийн үйлчилгээний  
мэргэжилтэн

Гишүүд:

М.Эрдэнэсүх

Агаарын навигацийн бодлого,  
зохицуулалтын газрын техникийн  
бодлого хариуцсан мэргэжилтэн

Ю.Золзаяа

Нисэхийн аюулгүй ажиллагааны  
хяналт, зохицуулалтын албаны  
Аэродром, агаарын  
навигацийн хяналтын хэлтсийн  
мэргэжилтэн

Т.Батбаяр

Нислэгийн урсгал төлөвлөлтийн  
албаны менежер


А.Тамир

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний  
албаны өгөгдлийн чанарын инженер

Ц.Ган-Эрдэнэ

Мэдээлэл технологи, инноваци  
судалгаа, хөгжлийн албаны менежер

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн  
А/808 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт



**“СИСТЕМ ДАЯАРХ МЭДЭЭЛЛИЙН МЕНЕЖМЕНТ” /SWIM/-ИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ**

**ЗОРИЛГО:**

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас дэвшүүлэн тавьсан “Систем даяарх мэдээллийн менежмент” /SWIM/ төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, Монгол Улсын агаарын навигацийн үйлчилгээнд нэвтрүүлэх

**ХАМРАХ ХҮРЭЭ:**

Монгол Улсын агаарын навигацийн үйлчилгээг бүхэлд нь хамарна.

**ХИЙГДЭХ АЖИЛ:**

1. “Систем даяарх мэдээллийн менежмент” /SWIM/-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ажлын төлөвлөгөөг дараах судалгаанд үндэслэн боловсруулан батлуулна.

- Ази номхон далайн бүсийн улс орнуудын “Систем даяарх мэдээллийн менежмент” /SWIM/-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг судлаж, уялдуулах
- Хөрш улс орнуудын агаарын навигацийн үйлчилгээний чиглэлд баримталж буй бодлогод судалгаа хийх, тэдгээрийн “Систем даяарх мэдээллийн менежмент” /SWIM/-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй нягт холбоотойгоор төлөвлөх
- Ази номхон далайн бүсийн VPN сүлжээ /CRV-Common regional VPN/ төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй нэгтгэх
- “Систем даяарх мэдээллийн менежмент” /SWIM/-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Бүсийн нислэгийн хөдөлгөөний шинэ төвийн агаарын навигацийн үйлчилгээний төлөвлөлт, тоног төхөөрөмжийн шинэчлэлттэй нягт уялдуулан төлөвлөх

2. Төлөвлөлтөнд нөлөөллийн шинжилгээг хийж, төлөвлөгөөнд хавсаргах

3. Систем даяарх мэдээллийн менежмент” /SWIM/-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор бүрэн боловсруулж Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулж батлуулна.

4. Батлагдсан төлөвлөгөөг Ази номхон далайн бүсийн иргэний нисэхийн олон улсын байгууллагад хүргүүлэх

**ГАРАХ ҮР ДҮН:**

“Систем даяарх мэдээллийн менежмент” /SWIM/-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулагдан батлагдсан байна.